



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Могод сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/48/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр: Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 100.
танай _____ ны № _____ т

МОГОД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ч.АЛИМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Могод сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Могод сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг байдал буруу илэрхийлэлтэй байна. Үүнд:

- ✓ Тогтмол зардал буюу цахилгааны зардлын 6 дугаар сард 442,400.00 /дөрвөн зуун дөчин хоёр мянга дөрвөн зуу/ төгрөг, 12 дугаар сард 65,000.00 /жаран таван мянга/ төгрөг, түлш халаалтын зардлын 5 дугаар сард 7,234,500.00 /долоон сая хоёр зуун гучин дөрвөн мянга таван зуу/ төгрөг, 10 дугаар сард 6,120,300.00 /зургаан сая нэг зуун хорин нэгэн мянга гурван зуу/ төгрөг, 12 дугаар сар 14,125,400.00 /арван дөрвөн сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуу/ төгрөг, халаалтын өр 12,835,000.00 /арван хоёр сая найман зуун гучин таван мянга/ төгрөгийн НӨАТ-ын баримтгүй гүйлгээ хийсэн.
- ✓ Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 450,000.00 /дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийн принтер, 3,260,000.00 /гурван сая хоёр зуун жаран мянга/ төгрөгийн шкаф, төмөр сейф, сандал, принтер зэрэг хөрөнгө бэлтгэсэн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн

D:/bichighereg/2022A4toot

006020268

тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын хавсралтад нийцэхгүй, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,011,151.08	78,138,729.08
35	БАРАА МАТЕРИАЛ	61,011,151.08	78,138,729.08
351	Түүхий эд материал	1,529,920.00	1,290,900.00
35130	Эм боох материал	1,529,920.00	1,290,900.00
354	Хангамжийн материал	59,481,231.08	76,847,829.08
35410	Бичиг хэргийн материал	1,603,432.00	1,443,050.00
35420	Аж ахуйн материал	4,623,100.00	10,536,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	8,500.00	8,500.00
35450	Барилгын засварын материал	-	928,750.00
35460	Хүнсний материал	1,722,800.00	2,515,830.00
35470	Бусад хангамжийн материал	51,523,399.08	61,415,599.08
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	870,797,417.84	797,154,754.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	870,797,417.84	797,14,754.25
392	Биет хөрөнгө	817,821,417.84	744,546,254.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	743,729,333.72	743,729,333.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(81,015,341.76)	(158,606,315.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,500,000.00	12,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,249,999.98)	(12,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	133,494,237.87	161,775,550.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,641,860.26)	(104,314,568.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,582,532.44	112,076,487.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,291,816.99)	(34,289,794.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,200,000.00	10,200,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,321,583.28)	(5,061,583.28)
39217	Ном	16,835,916.08	19,037,143.48
393	Биет бус хөрөнгө	52,976,000.00	52,608,500.00
39301	Програм хангамж	1,900,000.00	1,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(120,000.00)	(487,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,196,000.00	51,196,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	931,808,568.92	875,293,483.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	931,808,568.92	875,293,483.33
51	Засгийн газрын хувь оролцоо	931,808,568.92	875,293,483.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	354,268,948.85	354,268,948.85
51101	Өмч: - төрийн	354,268,948.85	354,268,948.85
512	Хуримтлагдсан үр дүн	(77,357,084.34)	(133,872,169.93)
51210	Өмнөх үеийн үр дүн	(77,357,084.34)	(77,357,084.34)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(56,515,085.59)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	654,896,704.41	654,896,704.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	931,808,568.92	875,293,483.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	834,324,276.00	792,407,772.46

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,218,376.00	133,287,600.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	133,287,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	133,287,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	820,105,900.00	659,120,172.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	697,117,000.00	511,895,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	697,117,000.00	511,895,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	295,800.00	17,209,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,514,536.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	295,800.00	1,695,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,693,100.00	130,014,836.46
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,693,100.00	130,014,836.46
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	842,146,672.97	873,727,194.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	842,146,672.97	873,727,194.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	729,066,967.70	842,781,768.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,717,809.35	493,661,736.65
210101	Үндсэн цалин	356,636,971.47	317,905,530.13
210102	Нэмэгдэл	78,537,122.88	137,559,691.59
210104	Урамшуулал	43,543,715.00	38,196,514.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,334,389.38	65,269,463.00
210201	Тэтгэврийн даатгал	41,103,498.45	46,622,309.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,817,170.49	4,699,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,382,154.18	3,806,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,422,421.31	945,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,609,144.95	9,196,253.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,216,921.00	129,014,836.46
210301	Гэрэл, цахилгаан	3,150,321.00	2,994,936.46
210302	Түлш, халаалт	117,066,600.00	125,837,900.00
210303	Цэвэр, бохир ус	-	182,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,510,707.00	9,489,315.74
210401	Бичиг хэрэг	1,024,907.00	1,636,140.74
210402	Тээвэр, шатахуун	1,834,800.00	2,027,525.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,000.00	504,400.00
210404	Ном, хэвлэл	130,100.00	182,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	268,900.00	132,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	475,600.00	229,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	364,400.00	4,777,050.00
2105	Нормативт зардал	18,138,965.00	17,302,410.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	702,300.00	1,855,220.00
210502	Хоол, хүнс	17,242,415.00	15,447,190.00
2107	Томилолт, зочны зардал	774,000.00	677,300.00
210702	Дотоод албан томилолт	774,000.00	677,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,233,200.00	316,515.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,909,200.00	316,515.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,038,815.97	127,050,191.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	883,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,421,900.00	2,547,632.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,616,915.97	123,619,159.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,079,705.27	30,945,426.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,400,765.00	18,072,317.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,508,265.00	17,622,317.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	892,500.00	450,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,678,940.27	7,393,609.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,678,940.27	7,393,609.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,479,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,479,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(7,822,396.97)	(81,319,422.13)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(25,914,928.56)	(81,319,422.13)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	354,268,948.85	654,896,704.41	-77,357,084.34	931,808,568.92	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	354,268,948.85	654,896,704.41	(77,357,084.34)	931,808,568.92	
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(56,515,085.59)	(56,515,085.59)	
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	354,268,948.85	654,896,704.41	(133,872,169.93)	875,293,483.33	

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	820,105,900.00	797,887,272.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	138,767,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,479,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,479,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,479,500.00

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	133,287,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	133,287,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	820,105,900.00	659,120,172.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	697,117,000.00	511,895,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	697,117,000.00	511,895,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	295,800.00	17,209,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,514,536.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	295,800.00	1,695,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,693,100.00	130,014,836.46
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,693,100.00	130,014,836.46
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	796,445,900.00	769,757,272.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	796,445,900.00	769,757,272.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	687,168,594.73	737,883,096.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,717,809.35	493,661,736.65
210101	Үндсэн цалин	356,636,971.47	317,905,530.13
210102	Нэмэгдэл	78,537,122.88	137,559,691.59
210104	Урамшуулал	43,543,715.00	38,196,514.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,334,389.38	65,269,463.00
210201	Тэтгэврийн даатгал	41,103,498.45	46,622,309.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,817,170.49	4,699,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,382,154.18	3,806,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,422,421.31	945,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,609,144.95	9,196,253.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,866,921.00	129,014,836.46
210301	Гэрэл, цахилгаан	3,150,321.00	2,994,936.46
210302	Түлш, халаалт	116,716,600.00	125,837,900.00
210303	Цэвэр, бохир ус	-	182,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,207,910.00	15,910,325.00
210401	Бичиг хэрэг	399,810.00	603,650.00
210402	Тээвэр, шатахуун	1,834,800.00	2,027,525.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,000.00	504,400.00
210404	Ном, хэвлэл	130,100.00	368,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,103,600.00	1,372,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,327,600.00	11,033,150.00
2105	Нормативт зардал	12,331,135.00	24,187,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	303,200.00	800,000.00
210502	Хоол, хүнс	10,269,535.00	21,719,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,758,400.00	1,668,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,223,810.00	2,695,000.00
210604	Урсгал засвар	1,223,810.00	2,695,000.00
2107	Томилолт, зочны зардал	774,000.00	677,300.00
210702	Дотоод албан томилолт	774,000.00	677,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,233,200.00	1,281,315.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,909,200.00	1,281,315.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,479,420.00	5,185,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,479,420.00	4,985,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,277,305.27	31,874,176.35

2132	Бусад урсгал шилжүүлэг	7,598,365.00	19,001,067.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,705,865.00	18,551,067.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	892,500.00	450,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,678,940.27	7,393,609.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,678,940.27	7,393,609.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,479,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,479,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>23,660,000.00</u>	<u>28,130,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>23,660,000.00</u>	<u>28,130,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>23,660,000.00</u>	<u>28,130,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	23,660,000.00	28,130,000.00
222001	Тоног төхөөрөмж	10,480,000.00	24,870,000.00
223001	Бусад хөрөнгө	13,180,000.00	3,260,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(23,660,000.00)</u>	<u>(28,130,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(0.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	776198300.00	767805163.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	776198300.00	749695163.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	756119600.00	730694096.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	494073700.00	493661736.65
210101	Үндсэн цалин	0.00	0.00	324100700.00	317905530.13
210102	Нэмэгдэл	0.00	0.00	131351100.00	137559691.59
210104	Урамшуулал	0.00	0.00	38621900.00	38196514.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	66524900.00	65269463.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	47042000.00	46622309.19
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	4824800.00	4699600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	3942500.00	3806200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	974200.00	945100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	9741400.00	9196253.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	129014900.00	129014836.46
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	2930000.00	2994936.46

210302	Түлш, халаалт	0.00	0.00	125902900.00	125837900.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	182000.00	182000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	16700900.00	12236325.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	409900.00	409650.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	2472500.00	2027525.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	505,200.00	504,400.00
210404	Ном, хэвлэл	-	-	328,100.00	368,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	1,230,500.00	1,372,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	11,754,700.00	7,553,150.00
2105	Нормативт зардал	-	-	27,411,000.00	23,867,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	482,100.00	480,000.00
210502	Хоол, хүнс	-	-	25,258,500.00	21,719,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	1,670,400.00	1,668,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	12,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	-	-	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-	1,009,900.00	677,300.00
210702	Дотоод албан томилолт	-	-	1,009,900.00	677,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	1,298,900.00	1,281,315.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	1,298,900.00	1,281,315.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	8,085,400.00	3,685,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	4,600,000.00	200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	3,485,400.00	3,485,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	20,078,700.00	19,001,067.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	20,078,700.00	19,001,067.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	-	19,628,700.00	18,551,067.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	450,000.00	450,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	18,110,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	-	18,110,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	14,850,000.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	3,260,000.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	129,014,900.00	647,390,136.46
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	511,895,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	-	511,895,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	129,014,900.00	130,014,836.46
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	129,014,900.00	130,014,836.46
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	5,479,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	5,479,500.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	17,209,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	7,189,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,189,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,674,000.00
210401	Бичиг хэрэг	-	194,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,480,000.00
2105	Нормативт зардал	-	320,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	320,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,695,000.00
210604	Урсгал засвар	-	1,695,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,020,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,020,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	10,020,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	17,209,536.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	17,209,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,514,536.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,695,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могод сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Могод сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Могод сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Хууль тогтоомж, Бага, суурь боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Багш ажилтан нэг бүрийн ажлын бүтээмж төлөвших хандлага сахилга хариуцлагыг сайжруулах

2. Судлагдахуун бүрээр сурагч нэг бүрээр сурагчдын сурлагын чанарыг ахиулах.

3. Сурагчдын бие бялдаг гоо зүйн хүмүүжил, иргэний ёс зүйн боловсролыг дээшлүүлэх гэсэн зорилтын хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээний баг бүрэлдэхүүнийг тушаал шийдвэрээр томилоогүй, дотоод хяналт хэрэгжүүлэх журам, заавар боловсруулж мөрдөж сар бүр гүйцэтгэлийн мэдээ гарган санхүүгийн албанд хүргүүлдэг. Байгууллагын удирдлага, болон албан хаагчаас тулгамдаж буй зүйлийн талаар сонсож, Орон нутгийн төсвөөр шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллаж байна. Дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могод сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 859874.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8598.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6019.1 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Могод сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мян.төг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	0	0	0
Бараа материал	61011.1	78138.7	-17127.5
Үндсэн хөрөнгө	1062438.02	1112414.5	-49976.5
Нийт хөрөнгө	931808.5	875293.5	56515.08
Өглөг	0	0	0
Хуримтлагдсан үр дүн	-77357.08	521024.5	443667.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	931808.5	875293.5	56515.08

Авлага: Оны эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 61011.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 78138.7 мянган төгрөг болж өмнөх оноос 17127.5 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 64404.1 мянган төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, 231.0 мянган төгрөгийн бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй орлого, 85.1 мянган төгрөгийг бараа материал шилжүүлэн авсан орлогоор тус тус нэмэгдэж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1062438.02 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1112414.5 мянган төгрөг болж өмнөх оноос 49976.5 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 28130.0, дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 2201.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд шилжүүлэн авсан 19645.3 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Өр төлбөр: Өглөгийн дансанд оны эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна. Санхүү байдлын, орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлага зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Могод сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд улсын төсвөөс 645183.4, орон нутгийн төсвөөс 130014.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Могод сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 он улсын төсвөөс 645183.4, нэмэлт дансаар 17209.5, орон нутгийн төсвөөс 130014.9, үндсэн үйл ажиллагааны орлого 5479.5 мянган төгрөг буюу нийт 797887.3 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 785014.2 мянган төгрөгийг зарцуулж 7393.6 мянган төгрөгийг төвлөрүүлж тайлагнажээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Могод сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд дээд шатны төсвийн захирагч, үндсэн үйл ажиллагааны орлогоос нэмэлт дансаар нийт 17209.5 мянган төгрөгийн санхүүжилт авснаас бичиг хэргийн зардалд 194.0, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 3480.0, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 320.0, урсгал засварын зардалд 1695.0, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 1500.0, тоног төхөөрөмжийн зардалд 10020.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Могод сумын ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйчийн орон тоог БШУЯ, БОЯ-аас хамтран зохион байгуулж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол-2” төслийн хүрээнд ажиллуулж байгаа боловч сургуулийн 2021 оны батлагдсан төсөвт цалингийн санд тус орон тоо батлагдаагүй байна. 2021 оны төсвөөс хэмнэгдсэн зардлаас 28130.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх данснаас 450.0 мянган төгрөгийн принтер, 3260.0 мянган төгрөгийн шкаф, төмөр сейф, сандал, принтер зэрэг хөрөнгө бэлтгэсэн Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Могод сумын ерөнхий боловсролын сургууль нь тогтмол зардал буюу цахилгааны зардлын 6 дугаар сард 442.4, 12 дугаар сард 65.0, түлш халаалтын зардлын 5 дугаар сард 7.234.5, 10 дугаар сард 6.120.3, 12 дугаар сар 14.125.4, халаалтын өр 12.835.0 мянган төгрөгийн НӨАТ-ын баримтгүй гүйлгээ хийсэн, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 450.0 мянган төгрөгийн принтер, 3.260.0 мянган төгрөгийн шкаф, төмөр сейф, сандал, принтер зэрэг хөрөнгө бэлтгэсэн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190

дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын хавсралтыг мөрдөж ажиллаагүйд зөвлөмж, албан шаардлага өгч ажилласан.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд 2021 онд 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч хугацаа хоцроож мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 3 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 91 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ажилчдын илүү цагийн бүртгэл, нэгтгэлтэй холбоотой анхан шатны баримтын бүртгэлийг архивлаж үдээгүй, цэгцгүй учраас анхаарал татахуйц байна. Иймд цалин, илүү цагийн нэмэгдлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 96887.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 24225.0 мянган төгрөгийн зөрчилд 2 залруулга хийж, 31840.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 40822.6 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Санхүүгийн тайлантай холбоотой залруулсан алдаа

Үндсэн хөрөнгийн дансанд худалдан авалт хийсэн хөрөнгө бэлтгэсэн 28130000 төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайлангийн Бага үнэтэй түргэн элэгдэх зардал-450000, Багаж техник, хэрэгсэл-10000000, Бараа үйлчилгээний бусад-4400000 төгрөгийн зардлуудын уялдаа холбоо, бичилт алдаатай байсныг залруулсан.

Үндсэн хөрөнгийн дансанд авто тээврийн хэрэгсэл Ланд-80 маркийн авто машины элэгдлийг буруу тооцсоныг залруулах бичилт хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага

4.3.1 Төсвийн хөрөнгөөр хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

4.3.2 Бага үнэтэй түргэн элэгдэх данснаас 450000 төгрөгийн принтер, 3260000 төгрөгийн шкаф, төмөр сейф, сандал, принтер зэрэг хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" мөрдөж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тогтмол зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цахилгааны зардлын 6 дугаар сард 442400, 12 дугаар сард 65000, Түлш халаалтын зардал 5 дугаар сард 7234500, 10 дугаар сард 6120300, 12 дугаар сар 14,125,400, халаалтын өр 12,835,000 төгрөгийн НӨАТ-ын баримтгүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг мөрдөж ажиллах.

2. Тээвэр шатахууны зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тээвэр шатахуун олголтыг хууль журмын дагуу олгоогүй.

Өгсөн зөвлөмж:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар заасан нормыг мөрдөж ажиллах.

3. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Эд хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

4. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Батлуулаагүй ажлын байрыг нэмэгдүүлж ажиллуулсан. /Цалингийн санд батлагдаагүй/

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан орон тоогоор цалингийн санд багтааж ажиллуулах.

5. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.5 дахь заалтын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		/мян/төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага	
1	Могод сумын	9	96887.6	2	24225.0	0	0	2	31840.0	5	40822.6